



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/255

Хэрлэн сум

Мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан
бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах,
худалдаалах, экспортлоход тавигдах шаардлагыг
хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.5.2.4-т туссан мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлоход тавигдах шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд шаардагдах 7,975,500 (долоон сая есөн зуун далан таван мянга таван зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хяналт шалгалтад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Мах бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлоход тавигдах шаардлагын хэрэгжилтэд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 08-34-02/056/01 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж явцыг тухай бүр, үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 21-ний дотор Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөрт), Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Эрүүл мэндийг газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Дашнамжилмаа), Байгаль орчны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Амгаланбат), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Э.Хонгорзул) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Э.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\Захирамж.2025

2310108.6

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ
МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД АЖИЛЛАХ ТОМИЛОГТ, ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2025 оны 05 дугаар сарын 05 -ны
 А.Б.С. дугаар захирамжийн хавсралт

№	Аймгийн нэр	Томилгоотоор ажиллах сум, дүүргийн нэр	Хяналт шалгалт хийх хяналтын чиглэлүүд		Нийт шалгах объектын тоо	Томилгоотын зардал (мян.төг)							Шатахууны зардал (мян.төг)							Бүх зардалын дүн (төг)
			Мал төхөөрөх	Мах боловсруулах		Ажиллах хоног	Нийт хүний тоо /жолооч орсон тоо/	Хоолны зардал (төг)	Буудлын зардал (төг)	Дүн (төг)	Сумдын зам (км)	Буцаж ирэх зам (км)	Шатахуун зарцуулалтын жишиг норм (л/100км)	Шатахууны хэмжээ (л)	Шатахууны үнэ (төг)	Дүн (төг)				
1	2	3	4		9		10	11	12	13	14		15	16	17	18	19			
1	Хэнтий	Хэрлэн	9	3	12		6			0				70	3250	227500	227500			
2		Бор Өндөр	2		2	3	6	30000	60000	1620000	190	190	16	60.8	3250	197600	1817600			
3		Дархан	2		2	2	6	30000	60000	1080000	160	160	16	51.2	3250	166400	1246400			
4		Өмнөдэлгэр	2		2	3	6	30000	60000	1620000	100	100	16	32	3250	104000	1724000			
5		Өлзийт	1		1		6				50	50	16	16	3250	52000	52000			
6		Батноров	4		4	4	4	6	30000	60000	2160000	100	100	16	32	3250	104000	2264000		
7		Жаргалтхаан	1		1	1	1	6	30000	60000	540000	100	100	16	32	3250	104000	644000		
Нийт дүн			21	3	24	13	42	150000	300000	7020000	700	700	96	294	22750	955500	7975500			

Жич: Холбогдох байгууллагууд Ланд круйзер 76 автомашинтай бөгөөд тэдгээр нь дизель хөдөлгүүртэй болно.

Тайлбар: Тус объектын жагсаалт нь 2024 оны эцэст үйл ажиллагааны бүртгэлтэй объект ба 2025 онд шинээр хүсэлт ирүүлсэн объектод ХХААХҮА, ЭМДамны Салбарын хяналтын улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан 08-00-02/10 дугаартай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийнэ.